



## БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай

Монгол улсын “Боловсролын тухай хууль”-ийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.6 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”-ийн 1.2 дахь заалт, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Боловсролын магадлын итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2014 оны 01 тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм” -ийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Ажлын албаны захирал /Ж.Ариунболд/-д даалгасугай.
4. Энэхүү дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ц.ЦОГЗОЛМАА



Боловсролын магадлан итгэмжлэх  
үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн  
2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн  
тоот тогтоолын хавсралт



## БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэнэ) нь дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үндэсний хэмжээний төв байгууллага мөн.

1.2. Үндэсний зөвлөлийн эрхэм зорилго нь сургалтын байгууллага, суралцагч, дэмжигч байгууллага, төр ба олон нийт, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан боловсролын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулан Монгол улсын боловсролын үнэлэмж, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг олон улсын түвшинд бэхжүүлэхэд оршино.

1.3. Үндэсний зөвлөл нь дараах зорилгыг хэрэгжүүлнэ:

1.3.1. Сургалтын байгууллагууд, хөтөлбөрийн чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, магадлан итгэмжлэх замаар үйл ажиллагааг нь тасралтгүй сайжруулах;

1.3.2. Магадлан итгэмжлэлийг тогтоосон хугацаанд хийж, сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар, нэр хүндийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх;

1.3.3. Үндэсний болон хамтран ажиллаж буй олон улсын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар ханган хамтарч ажиллах;

1.3.4. Монгол Улсын дээд, мэргэжлийн боловсролын нэр хүнд, байр суурийг олон улсад бэхжүүлэх;

1.4. Үндэсний зөвлөл нь хараат бус, бие даасан байдлаар ажиллаж, үйл ажиллагаагаа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

1.5. Үндэсний зөвлөл нь боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх чиг, үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлүүдийг ажил, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудын тэнцвэртэй оролцоотойгоор байгуулж, гэрчилгээ олгон бүртгэж, гэрээ байгуулан ажиллана.

1.6. Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа “Боловсролын тухай” хууль, боловсролын багц хуулиуд, Засгийн газраас баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”, холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.7. Үндэсний зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг

2.1. Үндэсний зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжилж, боловсролын чанарын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.2. Магадлан итгэмжлэгдсэн Сургалтын байгууллагуудын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг магадлан итгэмжилж, хөтөлбөрийн түвшинд чанарын ахицыг дэмжих;

2.1.3. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахын өмнө шинээр нээх хөтөлбөрт чанарын баталгаажуулалт хийж, урьдчилсан дүгнэлт гаргах, зөвлөн туслах;

2.1.4. Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага, мэргэжлийн холбоодоос судлан сонгож, гэрээ байгуулж, үндэсний бүртгэлд бүртгэж, үйл ажиллагаа явуулах эрх олгож баталгаажуулах, хамтарч ажиллах;

2.1.5. БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, хөтөлбөр олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэл хийлгэхээр хандана. Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг магадлан итгэмжилсэн тухай үндэсний магадлан итгэмжлэлийн байгууллагын шийдвэрийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд ОУМИБ-ын тогтоосон хугацааг баримтална.

2.1.6. Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг боловсруулан удирдах зөвлөлөөр баталгаажуулан мөрдөн хэрэгжүүлэх;

2.1.7. Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд баримтлах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоон, мөрдөж хэрэгжүүлэх

2.1.8. Сургалтын байгууллагууд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын чадавх бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.9. Сургалтын байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжилж, хүлээн зөвшөөрсөн тухай мэдээллээр боловсролын болон хөдөлмөрийн төрийн захиргааны төв байгууллагууд, сонирхогч талуудыг хангах;

2.1.10. Олон улсын ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, хөтөлбөрүүдийг гадаадад сурталчлах;

### **Гурав. Үндэсний зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт**

3.1. Үндэсний зөвлөл нь удирдах зөвлөл, ажлын алба, дээд боловсролын магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэх комисс, өргөдлийн хороо, хяналтын зөвлөл, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх мэргэжлийн зөвлөл гэсэн бүтэцтэй байна.

3.2. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комисс нь дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг хэлэлцэж мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах, сургалтын хөтөлбөрийн болон урьдчилсан чанарын баталгаажуулалтын тухай дүгнэлт, шийдвэрийг батламжлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэх комисс нь политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн магадлан итгэмжлэлийн асуудлыг хэлэлцэж дүгнэлт, шийдвэр гаргах, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шийдвэрийг батламжлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4. Мэргэжлийн зөвлөл нь тухайн ажил мэргэжлийн хүрээнд хамаарах хөтөлбөрт тавигдах мэргэжлийн онцлогийг тусгасан шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батлуулах, хөтөлбөрийг магадлан итгэмжлэх эсэх талаар шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцэн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.5. Үндэсний зөвлөлөөс эрх олгосон шинжээчдийг түшиглэн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Шинжээчийн эрхийг 3 жилийн хугацаагаар олгоно.

3.6. Магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөл болон шинжээчийн үйл ажиллагааны журмыг Удирдах зөвлөл батална.

3.7. Өргөдлийн хороо нь магадлан итгэмжлэх үйл ажиллагаа, шийдвэр, үр дагавартай холбоотой асуудлаар Үндэсний зөвлөлд ирүүлсэн гомдол, маргааныг шийдвэрлэх чиг үүрэгтэй. Өргөдлийн хороо нь боловсролын сургалтын байгууллага, суралцагчийн төлөөллөөс бүрдсэн байнгын 3 гишүүнтэй байна. Тухайн асуудалтай холбоотойгоор Үндэсний зөвлөлийн шинжээчдээс 2 хүнийг түр хугацаагаар авч ажиллуулна. Өргөдлийн хорооны түр гишүүнийг үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирлын тушаалаар тухай бүр томилно.

3.8. Хяналтын зөвлөл нь энэхүү журмын 12-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. Удирдах зөвлөл**

4.1. Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг түүний Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

4.2. Удирдах зөвлөл нь дарга, дэд дарга, төр, олон нийт, суралцагчийн төлөөллөөс бүрдсэн 9 гишүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

4.3. Удирдах зөвлөлийн дарга нь Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

4.4. Удирдах зөвлөлийн гишүүдийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батламжилна.

4.5. Удирдах зөвлөл доор дурдсан эрх эдэлнэ.

4.5.1. Үндэсний зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журам, шалгуурыг баталж мөрдөх, өөрчлөлт оруулах;

4.5.2. Байууллагын болон сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг баталгаажуулан мөрдүүлэх;

4.5.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас удирдлага, зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг тусалцаа авах;

4.5.4. Үндэсний зөвлөлийн ажлын албаны төсөв, бүтэц, орон тоог батлах,

4.5.5. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох;

4.5.6. Боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх шийдвэрийг батламжилж, гэрчилгээ олгох;

4.5.7. Магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөл, хяналтын зөвлөл, өргөдлийн хорооны бүрэлдэхүүнийг батлах;

4.5.8. Хуулиар зөвшөөрсөн бусад эрх;

### **Тав. Удирдах зөвлөлийн даргын эрх үүрэг**

5.1. Удирдах зөвлөлийн дарга нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

5.1.2. Удирдах зөвлөлийн хуралдааны товыг тогтоох, удирдах;

5.1.3. Удирдах зөвлөлийн дэд даргад хуралдааныг удирдах эрхээ шилжүүлж болно.

5.1.4. “Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ”-нд гарын үсэг зурж, гардуулах;

5.1.5. Бусад эрх үүрэг;

5.2. Удирдах зөвлөлийн дарга эрх шилжүүлснээр дэд дарга нь түр орлон ажиллах, удирдах зөвлөлийн хуралдааны товыг тогтоох, удирдах эрхийг хэрэгжүүлж болно.

### **Зургаа. Удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг**

6.1. Удирдах зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

6.1.1. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан санал хэлэх, асуулт асуух;

6.1.2. Магадлан итгэмжлэлийн баримт бичигтэй танилцах, хэлэлцүүлэгт оролцох;

6.1.3. Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, даргын өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

6.1.4. Магадлан итгэмжлүүлж буй байгууллагын тухай нууцыг чанд хадгалах;

6.2. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дараах нөхцөлд хүчингүй болгоно. Үүнд:

6.2.1. Чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

6.2.2. Удирдах зөвлөлийн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 удаа тасалсан;

6.2.3. Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн;

6.2.4. Бусад хүндэтгэх шалтгаан;

6.3. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд гарсан сул орон тоог 1 сарын дотор энэхүү дүрмийн хүрээнд нөхөн томилно.

### **Долоо. Удирдах зөвлөлийн хуралдаан**

7.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Удирдах зөвлөлийн хуралдаан байна. Зөвлөлийн хуралдааныг дарга, түүний эзгүйд дэд дарга даргалан явуулна.

7.2. Удирдах зөвлөлийн гишүүдийн хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хийж, сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх тухай болон бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.3. Удирдах зөвлөлийн хуралдааны товыг удирдах зөвлөлийн дарга тогтооно.

7.4. Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос дээш хувь нь хуралдаанд хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно. Хуралд хүрэлцэн ирсэн гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Удирдах зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ. Удирдах зөвлөл хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргаж, Удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Найм. Үндэсний зөвлөлийн Ажлын алба**

8.1. Үндэсний зөвлөлийн Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.1.1. Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, хуралдааны шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдааны шийдвэр, баримт бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.2. Үндэсний зөвлөлийн бүтэц, дүрэм журмыг өөрчлөх саналыг боловсруулж Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах;

8.1.3. Магадлан итгэмжлэгдсэн сургууль, хөтөлбөрүүдийн ахиц дэвшлийн тайланд чанарын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад санал хүргүүлэх;

8.1.4. Үндэсний зөвлөлийн бүтцийн нэгж, шинжээчдийг мэдээллээр хангах;

8.1.5. Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний сэтгүүл, ном товхимол, гарын авлага хэвлэн гаргах;

8.1.6. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын шинжээчийг сонгон шалгаруулах, эрх олгох, сургалт зохион байгуулж чадавхжуулах;

8.1.7. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болон хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

8.1.8. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах;

8.1.9. Магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

8.1.10. Үндэсний зөвлөлийн гадаад болон дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

8.1.11. Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, бүтээгдэхүүн нийлүүлэх, үндэсний зөвлөлийн санхүүгийн нөөц бүрдүүлэх, хянах, үр ашгийг дээшлүүлэх;

8.1.12. Ажлын албаны дотоод чанарын баталгаажуулалтыг ханган ажиллах;

8.1.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтооход дүгнэлт гаргах;

8.2. Ажлын алба нь Удирдах зөвлөлд ажлаа тайлагнана.

8.3. Ажлын албаны захирлыг Удирдах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн 5 жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа үргэлжлүүлэн сунгаж болно. Ажлын албаны захирал нь Удирдах зөвлөлийн дэд даргаар хавсран ажиллана.

8.4. Ажлын албаны захирал нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

8.4.1. Ажлын албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх;

8.4.2. Удирдах зөвлөлөөс баталсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажлын албаны ажилтан албан хаагчдыг ажилд томилох, чөлөөлөх болон ажилтнуудын хөдөлмөрийн харилцаатай холбоотой дотоод журам, бусад асуудлуудыг тушаал гарган шийдвэрлэх;

8.4.3. Ажлын албыг санхүүгийн удирдлагаар ханган хөрөнгө бүрдүүлэх, төсөв, төлөвлөгөөний дагуу захиран зарцуулах, хяналт тавих;

8.4.4. Үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулах;

8.4.5. Боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх шинжээчид эрх олгох, гэрээ байгуулан томилон ажиллуулах, ажлын гүйцэтгэлийг дүгнэх;

8.4.6. Үндэсний зөвлөлийг төлөөлөн гэрээ хэлэлцээр байгуулах;

8.4.7. Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, маягыг батлах;

8.4.8. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

8.5. Ажлын албаны ажилтнуудын нийгмийн болон хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудлыг дотоод журмаар зохицуулна.

8.6. Ажлын албаны захирал өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

### **Ес. Магадлан итгэмжлэх комисс**

9.1. Үндэсний зөвлөл нь Дээд боловсролын магадлан итгэмжлэх комисс, Мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэх комисстой байна.

9.2. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комисс нь дарга, 14 гишүүнтэй байна. Комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Төрийн захиргааны төв байгууллагын Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл -1
- Төрийн өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл - 3
- Төрийн бус өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл - 3
- Ажил олгогчийн төлөөлөл – 4
- Суралцагчийн төлөөлөл – 1
- Дээд боловсролын салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл – 1
- Шинжлэх ухааны байгууллагын төлөөлөл -1
- БМИҮЗ-ийн ажлын албаны төлөөлөл -1

9.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэх комисс нь дарга, 10 гишүүнтэй байна. Комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-1
- Төрийн өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл - 2
- Төрийн бус өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл - 2
- Техникийн болон мэргэжлийн боловсролын холбооны төлөөлөл -1
- Ажил олгогчийн төлөөлөл – 2
- Суралцагчийн төлөөлөл – 1
- Бүсийн аргазүйн төвийн төлөөлөл – 1
- Ажлын албаны төлөөлөл -1

9.4. Магадлан итгэмжлэх комиссын бүрэлдэхүүнийг Ажлын албаны саналыг үндэслэн удирдах зөвлөл батална.

9.5. Магадлан итгэмжлэх комиссын хуралдаанаас олонхын санал авсан гишүүнийг комиссын даргаар сонгож Удирдах зөвлөлийн дарга батламжилна.

## Арав. Үндэсний зөвлөлийн гишүүнчлэл

10.1. Үндэсний зөвлөл нь байгууллагын гишүүнчлэлтэй байна. Гишүүн байгууллага:

а/. Хүндэт гишүүн: Үндэсний зөвлөлийн бүртгэлд бүртгэгдсэн гадаадын болон олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага хүндэт гишүүн болж болно.

б/. Дэмжигч гишүүн: Үндэсний зөвлөл нь эрхэм зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг, хамтран ажилладаг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсүүлж болно.

в/. Хүндэт гишүүн, дэмжигч гишүүн элсүүлэх тухай шийдвэрийг БМИҮЗ-ийн удирдах зөвлөл гаргаж, батламж олгоно.

г/. Үндсэн гишүүн: Үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн сургууль нь үндсэн гишүүнээр шууд бүртгэгдэнэ.

10.2. Гишүүн байгууллага нь доор дурдсан нийтлэг эрхтэй. Үүнд:

10.2.1. Үндэсний зөвлөлийн эрх зүйн бичиг баримт, гарын авлага, арга зүйн зөвлөмж, ном, товхимлоор үнэ, төлбөргүй хангагдах;

10.2.2. Үндэсний зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Боловсролын магадлан итгэмжлэл” сэтгүүлийг үнэ төлбөргүй авах, сэтгүүлд материалаа хэвлүүлэх;

10.2.3. Үндэсний зөвлөлийн [www.acscom.mn](http://www.acscom.mn) сайтад шилдэг багш, шилдэг оюутан, шилдэг бүтээл, шинэ санаачилга төрлүүдээр мэдээ мэдээллээ түгээн сурталчлах, шалгаруулалтад оролцох;

10.2.4. Үндэсний зөвлөлөөс зохион байгуулах хурал, зөвлөгөөн, сургалт семинарт хөнгөлөлттэй нөхцөлөөр оролцох;

10.2.5. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, удирдлага, гишүүдийн асуудлаар мэдээлэл авах, санал гаргах, зөвлөгөө өгөх, шаардлага тавих зэргээр санал бодлоо илэрхийлэх;

10.3. Гишүүн байгууллага нь доор дурдсан нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд:

10.3.1. Үндэсний зөвлөлийн зорилго, зорилтыг дэмжин ажиллаж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулах;

10.3.2. Удирдах зөвлөл, бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд оролцох, дэмжлэг үзүүлэх;

10.3.3. Гишүүн байгууллага татвар, хураамж төлөхгүй. Үндэсний зөвлөл үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, өргөжүүлэхэд зориулан хандив өргөж, санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

10.4. Гишүүнчлэлээс тухайн байгууллага өөрийн саналаар татгалзаж болно. Энэ тухайгаа Ажлын албанд бичгээр мэдэгдсэнээр гишүүнчлэл дуусгавар болно.

Сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа нь дуусгавар болох, цуцлагдсан тохиолдолд үндсэн гишүүний бүрэн эрх дуусгавар болно.

10.5. Үндэсний зөвлөлийн гишүүдийн нэгдсэн хуралдааныг жилд нэг удаа хийж, дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

а/. БМИҮЗ-ийн ажлын албаны болон мэргэжлийн комиссуудын жилийн үйл ажиллагааны тухай мэдээллийг сонсох;

б/. Мэргэжлийн комиссын гишүүд, БМИҮЗ-ийн шинжээчид нэр дэвшүүлэх;



в/. Тэмдэглэлт, онцгой үйл явдалд зориулан хүндэтгэлийн хуралдаан хийж болно.

### **Арван нэг. Үндэсний зөвлөлийн санхүүжилт**

11.1.Үндэсний зөвлөл нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн хэм хэмжээг хангасан санхүүгийн журамтай байна. Санхүүгийн журам нь байгууллагын үйл ажиллагааны дотоод журмын салшгүй хэсэг байна.

11.2.Үндэсний зөвлөлийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

11.2.1.Улсын төсвийн санхүүжилт

11.2.2.Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны төлбөр

11.2.3.Үйлчилгээний орлого

11.2.4.Ивээн тэтгэлэг, хандив, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

11.2.5.Бусад эх үүсвэр

11.3.Үндэсний зөвлөлийн орлогыг дүрэмд заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулах ба ашиг хуваарилах, зээл олгох, хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно.

11.4.Үндэсний зөвлөлийн бүх шатны удирдлага, ажилтан, гишүүд хувийн ашиг олох зорилгоор эд хөрөнгийг ашиглах, байгууллагын нэр, албан тушаалаа ашиглан санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.5.Үндэсний зөвлөлийн санхүүгийн тайланг хууль, журмын дагуу гаргаж, холбогдох байгууллагад хүргэнэ.

11.6.Санхүүжилт, төсвийн ил тод байдал, зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд жил бүр дотоод хяналт хийж, хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

### **Арван хоёр. Үндэсний зөвлөлийн дотоод хяналт**

12.1.“Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”, “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилт, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

12.2.Хяналтын зөвлөл нь боловсролын сургалтын байгууллага, суралцагчийн төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Удирдах зөвлөл томилно. Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

12.3.Хяналтын зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

12.3.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, түүнд холбогдох дүрэм, журмуудын хэрэгжилтэд хяналт тавих

12.3.2.Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэлийн комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцон үг хэлэх, санал гаргах

12.3.3.Магадлан итгэмжлэгдсэн боловсролын сургалтын байгууллагаас Үндэсний зөвлөлийн ажлын албанд ирүүлсэн ахиц, дэвшлийн тайлан, мэдээ мэдээлэл болон боловсролын сургалтын байгууллагын ажилтай танилцах;

12.4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, шинжээчдийн үнэлгээ дүгнэлтэд нөлөөлөх, оролцогч талуудын нэр хүндэд нөлөөлөх нотолгоогүй мэдээлэл тараах зэрэг сөрөг үйлдлээс зайлсхийх үүрэгтэй.

12.5.Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

12.6.Хяналтын зөвлөл Удирдах зөвлөлд ажлаа танилцуулна.

---o0o---